



ОРХОН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 1752

Баян-Өндөр сум

Г Хөлбөмбөгийн U10, U11 насны хөвгүүдийн
улсын аварга шалгаруулах тэмцээнд
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам"-ын 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хөлбөмбөгийн U10, U11 насны хөвгүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг, тамирчдын төсвийг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтын дагуу санхүүжилтийн гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг спортын хэлтсийн дарга (Э.Лхамсүрэнбаатар)-д, спортын тэмцээн, наадмын бодлогын хэрэгжилт, зохион байгуулалт, тайлагналт хариуцсан мэргэжилтэн (Д.Дашбаатар)-д тус тус үүрэг болгосугай.

3.Тэмцээнд зарцуулагдах 4,410,000 (дөрвөн сая дөрвөн зуун арван мянга) төгрөгийг зохих журмын дагуу өсвөрийн шигшээ багийн зардлаас гаргаж, гэрээний дагуу шилжүүлэг хийхийг ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга (Ж.Нямжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д.ДЭЛГЭРБАЯР

Биеийн тамир, спортын газрын даргын
2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн
10/52.....дугаар тушаалын хавсралт

ХӨЛБӨМБӨГИЙН U10, U11 НАСНЫ ХӨВГҮҮДИЙН
УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Өдөр	Хүний тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд (төгрөгөөр)
1	Хоолны зардал	7	42	15,000	4,410,000
Төсвийн нийт дүн					4,410,000

---oOo---